

КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА



“Гермес Центр” ХХК нь 2003 онд байгуулагдсан бөгөөд компанийн төв нь нийслэл Улаанбаатар хотноо дэд бүтэц сайн хөгжсөн, А зэрэглэлийн бүсэд нийт 12 000 ам метр талбай бүхий 3 давхар худалдааны төвийн барилгад үйл ажиллагаа явуулж байна. Худалдаа үйлчилгээний төвийн барилга нь оффисийн барилга болох “А” болон худалдаа үйлчилгээний барилга болох “Б” корпусын барилгаас бүрдэнэ.

УБ хот дахь Гермес худалдааны төвийн орлого	Талбай /кв/м/	2007 он (хөндлөнгийн аудит хийлгэсэн)	2008 он (төсөвлөгдсөнөөр)
Нийт борлуулалтын орлого	12000	701.4 сая төгрөг	1 125.6 сая төгрөг
Цэвэр ашиг		383.4 сая төгрөг	394.0 сая төгрөг

“Гермес Центр” ХХК нь худалдааны төвийн түрээсийн үйл ажиллагааны зэрэгцээ БНХАУ-ын нэр хүнд бүхий Кипор, Мидеа, Сунинг компаниудын онцгой эрхт албан ёсны борлуулагчийн гэрээгээр гэр ахуйн цахилгаан барааны худалдаа, Дадди (Baoding Dadi Automobile Industry Co.,Ltd) автомашины үйлдвэртэй онцгой эрхт албан ёсны борлуулагчийн гэрээгээр автомашины худалдаа, засвар оношилгооны үйлчилгээ явуулдаг. Мөн эдгээр гэрээт компаниудын бараа бүтээгдэхүүнийг Эрдэнэт, Сэлэнгэ, Арвайхээр, Дархан, Сайншанд зэрэг хотуудын салбар дэлгүүрүүдээрээ худалдаалдаг. Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын гишүүн компани юм.

БИЗНЕСИЙН ТҮНШ

Манай компани хог хөдөөд борлуулалтын өргөн сүлжээ байгуулан хямд үнэ, өндөр чанар, өргөн сонголтыг санал болгох бөгөөд даатгал болон лизингийн үйлчилгээнд бүрэн хамрагдах боломжийг хамгарч ажиллаж буй байгууллагуудтай хийсэн гэрээ, хэлцлийн үр дүнд үйлчлүүлэгч иргэд, байгууллагууддаа олгож байна.

Бидний бизнесийн түнш байгууллагууд: “Голд цикл” ХХК, “Сайн компьютерс” ХХК, “ОХБ” ХХК мөн БНХАУ –ын “Gome” Хувьцаат компани, “Сунинг” корпораци



МОНГОЛ ШУУДАН БАНК

Монгол Шуудан банктай байгуулсан “Лизингийн Хамтын Ажиллагааны Гэрээ” -ний дагуу Гермес худалдааны товоор борлуулах гэр ахуйн болон автомашины санхүүжилтийг худалдан авагч нарт 0 хувийн урьчилгаа болон 100 хувийн лизингээр олгож байна.

website: www.postbank.mn



МИГ ДААТГАЛ ХХК

Хоёр байгууллагын хооронд байгуулсан гэрээний дагуу Гермес худалдааны товоор борлуулах гэр ахуйн бараа болон автомашиныг эд хөрөнгийн даатгалд нэг жилийн турш 100 хувь хамруулдаг.

website: www.mig.mn



BAODING DADI AUTOMOBILE INDUSTRY CO., LTD

Тус компани нь Бээжингээс 138 км-т орших БаоДин хотод байрладаг. Pick-up, SUV төрлийн автомашин үйлдвэрлэгч хамгийн том компанид тооногдог бөгөөд ISO9001 олон улсын чанарын баталгаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Орос, Америк, Зүүн өмнөд Азийн орнууд, Дундлал ази зэрэг нийт 40 улсад машинаа борлуулдаг бөгөөд жилд нийт 50 000 ширхэг машин үйлдвэрлэх хүчин чадалтайгаар ажилладаг.

website www.bddqc.com.cn



MIDEA GROUP

Midea Group нь 1968 онд байгуулагдсан бөгөөд Хятадын хамгийн том электрон бараа үйлдвэрлэгчдийн нэг юм. Одоогоор 70 000 гаруй харилцагчтай бөгөөд дэлхийд 12 төрлийн бүтээгдэхүүнээрээ алдартай юм. Гол бүтээгдэхүүнүүд нь агааржуулагч, цахилгаан зуух, угаалгын машин, цахилгаан халаагуур, аята таваг угаагч, тоос сорогч гэх мэт гэр ахуйн цахилгаан бараанууд.

website www.midea.com.cn,



WUXI KIPOR POWER CO.,LTD

KIPOR GROUP нь анх “КАМА” нэртэйгээр 1998 байгуулагдсан бөгөөд дижитал зөөврийн цахилгаан үүсгүүр, зөөврийн усны насос, дуу чимээ бага дижитал генератор, гэрэлтүүлэгч пампагууд гэх мэт өндөр чанартай бүтээгдэхүүнүүд үйлдвэрлэдэг. Импортлох бүтээгдэхүүн: Дижитал зөөврийн цахилгаан үүсгүүр, Зөөврийн усны насос, дуу чимээ бага дижитал генератор, гэрэлтүүлэгч пампагууд.

website www.kipor.com